

ХУБИЛАЙ ХААНЫ ТҮҮХЭНД ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Ж.Баясах¹

Хубилай хааны амьдрал, түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийг талаар тусгайлан судалсан эрдэмтэн бол Моррис Россabi юм. Моррис Россabi АНУ-ын Нью-Йорк хотын Их Сургуулийн профессор, Колумбын Их Сургуулийн зочин профессор хүн юм. Тэр Африкт төрсөн бөгөөд өрнөдөд боловсрол эзэмшиж улмаар АНУ-д очиж суурьшсан ховрой үндэстэн юм. Тэрээр араб, перс, хятад хэл мэддэг тул эдгээр хэл дээр бичигдсэн ном зохиолыг өргөн ашигладгаараа гайхалтай. Тэрээр “Khubilai Khan: His life and times” номыг 1988 онд хэвлүүлсэн байна.

Манай улсад академич Ч.Далай “Юань гүрний үеийн Монгол” номыг 1978 онд Улаанбаатар хотноо хэвлүүлсэн. Арван жилийн дараа уг номыг “Монголия в XIII-XIV веках” нэртэйгээр Н.Ц.Мункуевын нэмэлт орчуулгатайгаар Москва хотноо орос хэлээр хэвлэгдсэн бөлгөө. Манай улсад Юань улсаар дагнан судалгаа хийсэн эрдэмтэн бол Ч.Далай гуай болно. Тэрээр жилийн өмнө ертөнцийн мөнх бусыг үзжээ. Эрдэмтэн Ч.Далай Бээжингийн Их Сургуулийн түүхийн ангийг төгссөн анхны монгол байсан бөгөөд хятад сурвалж өргөнөөр ашигладаг судлаач байсан. Тэрээр Юань улсаас гадна Монголын бөө мөргөл, Монгол-Хятадын XX зууны сүүлийн хагасын харилцааг судалсан бүтээлүүд гаргасан. Түүхч Ш. Нацагдорж “Хубилай эцэн” ном гаргасан. Мөн түүх Ж.Урангуа, Д.Энхцэцэг нар “Монгол хатад” хэмээх номондоо Хубилай хааны хатан Чимбайн талаар бичжээ.

Өдгөө нанхидач Д.Наран Юань улсын үеийн Монголын төр ёсны боловсролыг судлан гаргаж 2001 онд нэг сэдэвт зохиол хэвлүүлсэн. Тэрээр мөн Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойгоор бусад эрдэмтдийн хамтаар “Монголын Юань улс” гэсэн хамтын бүтээл гаргасан. Өнгөрсөн хавар Дархан хотын 10-н жилийн сурагч өдгөө МУИС-ийн түүхийн ангийн оюутан Ч.Содбилиг “Монголын Их Юань Улсын түүх” ном бичсэн, манайд урьд өмнө үзэгдээгүй сонин зүйл болсон.


Монголын түүх бичлэгт Хубилай хааны гүйцэтгэсэн үүргийг хоёр янзаар бичсэн байдаг. Социализмын үед түүнийг Монголын түүхэнд ихээхэн харгис үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж, бичиж байв. Харин сүүлийн үед энэ үнэлгээнд зарим нэгэн өөрчлөлт орж байна.

Монгол Улс төрийнхөө ордны өмнөх Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөө цогцолборт Хубилай хааны баримлыг байршуулжээ.

¹ МУИС-ийн ОУХС-ийн тэнхмийн эрхлэгч, профессор, түүхийн шинжлэх ухааны доктор, bayasakhjk@gmail.com

Миний бие Орос улсад дорно дахины түүхийн ангийг төгсч МУИС-д багшилж бараг 30 жилийн нүүр үзэх гэж байна. Түүхийн ухааны докторын зэргийг /Ph.D/ 1989 онд, Түүхийн шинжлэх ухааны докторын зэргийг /Sc.D/ 2004 онд Өмнөд Сүн улсын элч нарын тэмдэглэлийг судлаж тус тус хамгаалсан. Хятад хэлийг ОХУ-д, дараа нь 1986 онд Бээжингийн хэлний дээд сургуульд сурч мэргэжил дээшлүүлсэн.

Энэ удаагийн Эрдэм шинжилгээний хуралд “Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг” сэдвээр илтгэл тавьж байна. энэхүү илтгэлд байгаа санаа оноог БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт Жаргалсан нөхрийн бүтээн байгуулах гэж байгаа Хубилай хааны орд, аялал зугаацлын төвд санаа авбал үүнийг тэрлэгч мань баярлах болно.



Үүнийг Моррис Россabi “Хубилай хаан” хэмээх нэг сэдэвт зохиолдоо гаргасан байдаг. Үүнээс үзвэл Хубилай хаан бол шууд алтан ургийн хүн болох нь тогтоогдож байна. Ах дүү дөрвийн том нь Мөнх хаан, Гүюүг хааны дараагаар хаан ширээ залгамжилж суужээ. Мөнх хаан ширээнд сууж байхдаа Хубилайд Умард Хятадыг захируулж байсан. Мөнх хааныг өөд болсны дараагаар Умард Хятадыг захирч нилээдгүй нэр хүнд олоод байсан Хубилай 1258 онд хаан ширээнд сууж 1294 он хүртэл Их Юань гүрний хаан байсан. “Юань” хэмээх улсын нэрийг “өнө” гэдэг үгнээс гаралтай хэмээн монголын түүхчид үздэг. “Өнө” гэдэг нь өнө мөнхийн “өнө” гэдэг үгнээс гаралтай.

Мөнх хааныг амьд сэрүүн ахуйд Өмнөд Сүн улсыг Хубилай эзлэхийн тулд өнөөгийн Юнь-нань мужид оршин тогтнож байсан Та-ли улс руу эхлэн довтолж номхотгосны дараагаар урдаас нь дайрах бэлтгэлийг тэрээр гардан бэлтгэж байсан. Та-ли улс нь жижиг ханлиг байсан агаад Сүн улстай хамтаар Монголын Юань улсын эрхшээлд орсон.

Хубилай хааны ээж Сорхагтани Беки хатан их элдэвтэй сүрхий хатан байсан талаар Плано Карпини, Рашид Аддины номд магтан өгүүлсэн байдаг. Ховрой эмч Бар Хебраус шүлэг зохиосон байдаг бөгөөд түүндээ хатныг “агуу эмэгтэй” хэмээн бичжээ³. Сорхагтани Беки хатан Хэрээдийн Ван Ханы ач охин бөлгөө. Түүнийг Чингис хаан хүү Тулуйдаа бэр буулгасан хэмээн түүхэнд тэмдэглэсэн байдаг. Тулуй хааны талаар тэрээр “аав Чингис хаантайгаа хамт аян дайнд морддог

² Morris Rossabi, “Khubilai Khan: His life and tTimes”, University of California Press, p.19

³ Ibidium, p.12.


байсан. Их хааныг өөд болсны дараагаар 1231-1232 онд Тулуй Өгөөдэй хаантай хамт Зөрчидийн эсрэг аян дайнд мордож байсан бөгөөд Өгөөдэйн өмнөөс бөөгийн ёсоор амиа золиослосон бололтой. “Монголын нууц товчоон”-д ч гэсэн Тулуй хэрхэн өөд болсон талаар асар бүрхэг байдаг. Сорхагтани хатан дөрвөн хүүгээ сүрхий хүмүүжүүлсэн бөгөөд хүү нараа хаан ширээнд суулгахын төлөө их зүйл хийж байсан хэмээн түүхэнд бичжээ. Үнэхээр ч Өгөөдэйн хүү Гүюүг хаан ширээнд тавхан жил /1246-1251/ суусны дараагаар 1251 онд Их Хуралдай болж Мөнх хааныг хаан ширээнд залсан. Мөнх хаан Өмнөд Сүн улсыг эзэлж авахын төлөө ихээхэн хүчин чармайлт гаргасан хэдий ч уг аянаа гүйцээж чадаагүй. Өмнөд Сүн улсыг эзлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хүн бол яриангүй Хубилай хаан мөн юм. 1258 онд Мөнхийн дүү Хүлэгү аббасидуудыг дараад Багдад хотыг эзэлж авсан. Улмаар тэр Ил Хаан улсыг байгуулж эзэгнэн суусан. Хүлэгү дүү Хубилайгаа байнга дэмжиж байсан бөгөөд түүнийг хаан ширээнд суугаад өөд болтол нь Хүлэгүгийн хүүхдүүд өөрөөр хэлбэл Ил Хааны улс Юань гүрнийг ялангуяа Хубилайг дэмжиж байсан. Харин Алтан ордны улс Цагаадайн ач нар Хубилай хааныг дэмждэггүй байсан байх юм.

Хубилайг хаан ширээнд суухад Хуралдайг Монголд хийгээгүй Умард Хятадад хийсэн тул монгол нутгаа захиран сууж байсан Аригбөх эсэргүүцэж тэрсэлдсэн талаар түүхэнд бичигдсэн байдаг. Аригбөхийг Зүчи, Цагаадайн хүүхдүүд дэмжиж байсан хэдий ч Хубилай хаан номхруулж чадсан. Ил хааны улс нь өнөөгийн Иран, Афганистаныг эзэлж байсан бөгөөд эл улсуудыг нэгтгээд “Перс” нэрийддэг. Эдгээр нутгийн хүн ард нь фарси буюу перс хэлээр ярьдаг. Эдгээр улсын талаар Рашид Аддин “Судрын чуулган” зохиолдоо дэлгэрэнгүй бичсэн байдаг.

Сорхагтани хатан хоёр дахь хүүгээ хаан болохыг үзсэн байна. Аль аль нь суурин газрын амьдрал ашиг ихтэй болохыг эрт ухаарсан бөгөөд харьяандаа байсан улсыг нэгдсэн бүртгэлд оруулж данс хараатай болгосон. Ингэснээр татвар авах явдлыг жигдрүүлж сан хөмрөгөө арвижуулсан. Өмнөд Сүн улсыг эзлэхийн тулд Та-ли улсыг эзлээд тэнд Сүн улс руу довтлох түшиц газрыг хийж, тариа тариулж байсан хэмээн сурвалжууд өгүүлсэн байдаг.

Хубилай хаан дөрвөн хатантай байсан. Бүгд монгол хатад байжээ. Тэрээр ордондоо асар олон эмстэй байсан талаар Марко Поло бичсэн байдаг бөгөөд тэдгээр олон эмстэй цэнгэдэг байсан, тэднийг шалгаруулж авахдаа амьсгалын зам, бие галбир зэргийг нь үзлэгт оруулж авч байсан мэтээр бичсэн байдаг. Дөрвөн хатнаас дөрвөн хүү, хоёр охинтой байжээ. Дөрвөн хатдын хамгийн ойр нь Чаби хатан байжээ. Хубилай хааны гол зөвлөдөг хүн нь Чаби хатан байсан байна. Тэрээр мөн нүүдлийн амьдралаас илүү суурин амьдралыг илүүд үздэг байж. Тэргүүн хатан Төгүлүн хэмээх хатан байжээ. Чаби хатнаас Жэнзинь, Дорж, Мангалай, Номухан дөрвөн хүү төрсөн бололтой. Удаах хатан нь Намби гэдэг байж, түүнээс нэг хүү төрсөн хэмээн бичдэг. Дөрөвдөхь хатан хэн болох талаар одоохондоо мэдэгдээгүй байна.

Хубилай хааны хөрөг



Чаби хатны хөрөг



Тайваний Үндэсний музей

Хубилай хааны үйл амьдрал

Хубилай хаан балчир ахуйгаасаа хятад бичиг үсэг сураагүй. Юань улсын эзэн хаан болсон хойноо ч гэсэн хятад бичиг сураагүй, сурахыг ч бодоогүй. Тэрээр өөрийгөө “Даян дээрх Их хаан” гэж боддог байж. Үнэхээр их гүрний эзэн хаан байсан нь үнэн. Тэр Өмнөд Сүн улсыг эзлэж авсан, Солонгосыг төвшитгөсөн. Өөрийн охин Хутулай Чэлимэшийг Солонгосын хаантай ураг барилдуулсан. Солонгосоос жил бүр “толгой” албанд Солонгосын хэдэг мянган язгууртны хүүхдүүдийг барьцаанд байлган хаад ноёдыг нь номхон байлгадаг аргатай байжээ.

Хубилай хаан Японыг эзлэх гэж хэд хэдэн удаа оролдсон тухай түүхэнд гардаг. Японыг хэд хэдэн удаа эзлэх гэж үзсэн хэдий ч тухай бүрд нь далайн шуурганд нирвэгдэж монголын цэрэг Японыг эзлэж чадаагүй. Тухайн үед Япон дотроо хагаралтай байсан. Хагаралдуулж байсан нэг тал нь хааны ордныхон, нөгөө тал нь шогуныхан байсан. Монголчууд усан цэргээ бэлдэхдээ Солонгост бэлдэж байсан. 1266, 1271, 1272, 1274 онд монголчууд Япон руу цэрэг хөдөлгөж байсан. 1274 оны 11 дүгээр сард Бусанаас 15 мянган цэрэг хөдөлгөж байжээ. Солонгосуудаар 300 том онгоц, 400-500 жижиг онгоц бариулж Кюсю арлын Цүсимад тэдгээр цэргүүд нь газардсан байна. Тулалдааны үеэр далайн шуурга тавьж 13 мянган хүн амиа алдсан байдаг.⁴ Хубилай хаан Япон улсыг эзэлж чадаагүйдээ сэтгэл гонсгор байсан. Аргагүй байдлаас эл төлөвлөгөөгөө хэрэгжүүлж зорилгодоо хүрч чадаагүй юм.

Хубилай хаан бүх Хятадыг эзэлж аваад засаг захиргааны өөрчлөлт хийсэн. Харьяа нутагтаа даргучи нарыг томилсон. Хятадын уугуул нутгийг захирахдаа монголчууд буюу харь угсаатнаар “даргучи” болгодог байсан. Гурван их сайдтай байсны нэг нь лалын гаралтай Ахмад байсан. Ахмад “Хубилай хаанд үнэнчээр зүтгэдэг байсан” гэж персийн түүхчид бичдэг байсан бол Хятадын түүхчид түүнийг “ховдог шунахай сэтгэлтэй, хэрцгий нэгэн байсан” гэж түүхэнд бичиж үлдээжээ.

⁴ Ibidium, pp. 100-103

Сан хөмрөгөө арвилахын тулд бүх хятадын хэмжээнд данс хараагаа шинэчилсэн. Мөн цаасан мөнгөн тэмдэгтийг бий болгосон. Өртөөний албыг их гүрэн даяар бий болгосон. Өмнөд Хятадыг Умард Хятадтай холбож их сувгийг засварлан шинэчилж уртасгажээ. Газар тариаланд шинэчлэлт хийж улирал өнжүүлгийн талбайнуудыг бий болгосон. Нийслэлээ өнөөгийн Бээжинд авчирсан. Тухайн үедээ Дадү хэмээн нэрлэдэг байсан ба энэ нь хятадаар “Их нийслэл” юм. Урьд нь Алтан улсын нийслэл Жүндү хэмээх нийслэл байсны суурин дээр Юань гүрний нийслэл Дадуг босгосон. Хубилай хаан Кайпин хотод дээд нийслэл Шандыг байгуулсан. Шанд нийслэлдээ зуны цагт Хубилай суудаг байсан ба тэндээ ан ав хийдэг газартай байжээ. Тэнд гэр босгож өргөөлөн суудаг байсны дээр тэндээ бөө сахиус шүтээнээ тахидаг байв.



Хубилай хаан ан хийж байгаа нь, Тайваний Үндэсний музей.

Эдийн засаг, засаг захиргаа, газар тариалангийн шинэчлэлт нь Хятадын уламжлалыг хадгалсан аястай байсан. Уугуул нутагтаа хятад хүнийг хөл тавиулахгүйн дээр тариа тариулж газар хагалуулахгүй, хятад хүнийг суурьшуулахгүй, хятад, монгол хүнийг хооронд нь цус холилдуулахгүй, тэр байтугай хятад хүмүүст монгол хэл заахыг хориглодог байсан. Мөн Юань гүрэнд хийсэн бас нэг том шинэчлэл нь бичиг үсэгжүүлэхийн зэрэгцээ боловсролын системд өөрчлөлт хийсэн. Уйгаржин монгол бичгээр хятад үсэг, хятад үг, нэр томъёог галиглан буулгахад хүнд байсан учраас Түвдийн Пагва ламыг дэргэдээ залж дөрвөлжин үсгийг зохиолгуулсан байна. Дөрвөлжин үсгийг түвд үсгийн суурин дээр зохиосон учраас уг үсгээр хятад үг үсгийг тэмдэглэхэд хялбар байсан. Хубилай хааны зарлигаар дөрвөлжин үсгийг эзэнт улсын хэмжээгээр хэрэглэх болж зарим хятад бичвэрийг дөрвөлжин үсгээр галиглан бичсэн нь ч бас тааралддаг. Чингисийн үеэс хэрэглэж байсан гэрэгэн дээрх бичиг нь дөрвөлжин үсгээр бичсэн байдаг. /Зургийг хавсаргав./



Дөрвөлжин үсгээр бичсэн хүрэл гэрэгэ

Тэр үед хийж байсан шаазан эдлэлийн ёроолд нь дөрвөлжин үсгээр “Юань” гээд дарсан байдаг⁵. Хубилай хааны үед савлаж байсан дарсны бортог дээр “сайн дарсун” гээд бичсэн байдаг.

Сүн улсыг эзэлж авахын тулд мөн Умард Хятадыг захирч эхлэх эхэн үедээ Хубилай хаан хятад олон зөвлөх нартай байжээ. Түүний нэр нөлөө ихсэх тоолонгоор хятад зөвлөхүүдийн албанд авах явдлыг багасгасан. Зөвлөхүүдийн ихэнх нь кунзын сургаалтан байсан. Хубилай хаан ширээнд сууж байх эхэн үед бурхны шашинтан хийгээд дао буюу бомбын сургаалтан нар хоорондоо эв түнжин муутай байсныг эвлэрүүлж чадсан. Хубилай лалын шашинтныг төрийн албандаа их зардаг байсан учраас түүнийг лалын шашныг дэмжигч байсан гэж персийн түүхчид бичдэг. Угтаа бол Хубилай шашныг дэмжиж байсан биш уугуул хятад иргэдийг захирч хянаж байхын тулд өнгөт нүдтэн, лалын шашинтныг ашиглаж байсан ба тэднийг өөртөө татах арга байсан.

Хубилай хаан аливаа нэгэн шашныг гадуурхдаггүй, хүлцэнгүй /tolerant/ ханддаг их хаан байжээ. Тэрээр харийн элч, гийчдийг дотночлон авч уулздаг байсан нь өөртөө татах арга байсан. Тухайлбал Венецийн худалдаачин Марко Полог ордондоо 18 жил байлгасан. Тэр нь нутаг буцаж очоод дахин ирсэн. Эцэст нь энэ хүн “Азиар зорчсон нь” гэдэг гайхалтай ном бичсэн нь өнөөг хүртэл үнэ цэнээ алдаагүй байна. Хубилай хаан мөн гар урчуудыг онцгой дэмжих бодлого явуулдаг байжээ. Хубилай хааны үед Балбаас уран дархан авчирч тэднийг дэмжих бодлого явуулж тэр ч атугай татвараас чөлөөлж байжээ. Тухайн үед төмөр, чулуу, арьс, модон урлал их хөгжиж байсны дээр шаазангийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж монголчууд бидний хэрэглэж заншсан “будаатай” шаазанг тэр үеэс хийж эхэлсэн байдаг.

Өдгөө Тайваний Үндэсний музейд ёроолдоо дөрвөлжин үсгийн дардастай тийм шаазангууд хадгалагдаж байна. Мөн Юань улсын үед “Юаны жүжиг” хэмээх театрын дэг сургууль бий болсон. Өнөө хүртэл хадгалагдаж байгаа тэр үеийн 57 жүжиг байдаг. Тэр үеийн жүжгийн хэл нь ярианы хэл байсан учраас хятад хэлний бичгийн хэл ярианы хэлийг ойртуулж өгсөн бас нэг сайн талтай байжээ.

⁵ Ж.Баясах, “Хятадын товч түүх”, 141-р тал

Дүгнэлт


Хубилай хаан бол алтан ургийн үр удам мөн.

Суурин нүүдлийн соёлыг хослуулахыг оролдсон зүтгэлтэн.

Шашинд өвөг дээдэс лугаа адил хүлцэнгүй ханддаг нэгэн байсан.

Хятадын эдийн засаг, засаг захиргаанд асар их хувь нэмэр оруулсан том гүрний их хаан байсан.

Миний судалгаагаар Чингис хаан хийгээд түүний залгамжлагчдын ургийн мод



Ном зүй

Morris Rossabi, "Khubilai Khan: His life and Times", University of California Press

Ч.Далай, "Юань гүрний үеийн Монгол", УБ, 1973

Ч.Далай, "Монголия в XIII-XIV веках", М., 1983

Ж.Баясах, "Хятадын товч түүх /нэн эрт үеэс Дундат Иргэн Улсын эхэн", УБ, 2002

Д.Наран, "Монголын төр ёсны боловсролын түүх", УБ, 2001

Ч.Содбилиг "Монголын Их Юань Улсын түүх", УБ, 2010